

БАРУУН БҮСИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХИЙГЭЭД ХЯТАД-МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, ХУДАЛДААНЫ ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Насан**
*Мэн Липин***

Монгол улс бол БНХАУ-ын хамгийн чухал хөрш орон болно. 1949 оны 10-р сарын 16-нд Хятад-Монгол хоёр орон дипломат харилцаа байгуулж хоёр орны түүхийн шинэ үеийг нээсэн байна. Хоёр орны хооронд уламжлалт харилцаатай билээ. Одоо хоёр талд улс төрийн талаар шийдвэрлэгдээгүй ямар ч асуудал байхгүй.

XX зууны 90-ээд оны эхээр олон улсын харилцаанд өөрчлөлт гарснаас нааш, түүхийн шинэ нөхцөл доор Хятад-Монголын харилцаа ч ихээхэн хөгжсөн байна. Хятадын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Ли Пэн, Монгол улсын ерөнхий сайд П.Жасрай нар 1994 оны 4-р сарын 29-ний өдөр Улаанбаатарт гарын үсэг зурсан “БНХАУ, Монгол Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ” бол хоёр орны харилцааны түүхэн дэх цаг үеийг заагласан үйл явдал болж, шинэ эриний Хятад-Монголын найрамдал хамтын ажиллагааны харилцааг хуулиар баталгаажуулж, хоёр орны харилцаа урт хугацаагаар тогтуун, эрүүлээр хөгжихөд улс төрийн суурь тавьж, хоёр орны хоорондохь бүх талын ажлуудыг зохицуулж шийдвэрлэх үндсэн зарчмыг тогтоож өгсөн байна. Үүний суурин дээр Хятад-Монгол хоёр орон хил тогтоох ажлаа урагштай дуусгаж хоёр орны найрамдалт хөршийн харилцааг улам эрчимжүүлэн бэхжүүлсэн байна. 1998 оны 12 –р сард Монгол улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Хятадад, 1999 оны 7-р сард Хятад Улсын дарга Зян Зэминь Монгол улсад айлчилсан явдал нь хоёр орны харилцааг шинэ шатанд гаргаж Хятад-Монгол хоёр орон XXI зуунд хандсан урт хугацааны тогтвортой, эрүүд, харилцан итгэлцсэн найрамдалт хөршийн харилцааны чиглэлийг тодорхойлсон байна. Сүүлийн

*Насан - ӨМӨЗО-ны Зүүн хойт Ази судлалын хүрээлэнгийн орлогч захирал, профессор

** Мэн Липин (БНХАУ)

жилүүдэд Азийн орнуудын хоорондох эдийн засаг худалдааны хамтын ажиллагаа нэмэгдэхийн хэрээр Хятад-Монгол хоёр орны эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа ч түргэн хөгжиж, одоо Хятад нь Монгол улсын худалдааны нэгдүгээр түнш болоод байна.

Хятад орон одоо баруун бүсийн хөгжлийг түргэтгэх стратегийг хэрэгжүүлж байна. Энэ нь Хятад-Монголын эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны хөгжилд нэн таатай түүхэн завшаан, болох бөгөөд шинэ эрч хүч өгөх юм. Энэхүү өгүүлэлд Хятадын баруун бүсийг хөгжүүлэх ба Хятад-Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаанд үзүүлэх нөлөө болон Хятад-Монголын эдийн засаг худалдааны хамтын ажиллагааг түргэн хөгжүүлэх зэрэг асуудлыг хөндлөө.

Нэг. Хятадын баруун бүс нутгийг хөгжүүлэх ба Хятад-Монголын эдийн засаг худалдааны хамтын ажиллагаанд үзүүлэх нөлөө

Хятадын засгийн Газар баруун бүсийг хөгжүүлэх стратеги хэрэгжүүлж 5-10 жилийн хугацаанд баруун бүсийн дэд бүтэц, экологийн орчны бүтээн байгуулалтыг огцом ахиулж, шинжлэх ухаан технологи, өвөрмөц эдийн засаг, давуу талт аж үйлдвэрийг нэлээд хөгжүүлж, өөрчлөлт нээлттэй бодлогын шинэ байдал бий болгож, ард түмний амьдралыг мэдэгдэм сайжруулж, улам цаашид хөгжүүлэх сайн суурь тавьж өгнө. Хятадын баруун бүсийг хөгжүүлэх стратегийг хэрэгжүүлэх нь Монгол улсын хөгжил ба Хятад-Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаанд нэлээд их нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

/Нэг/ Баруун бүсийг хөгжүүлэх стратегийн зорилт нь Хятадын баруун бүсийн эдийн засгийн хөгжлийг түргэтгэж, зүүн баруун бүсийн хоорондох зөрөөг багасгаж, Хятадын эдийн засгийг тэнцвэртэй хөгжүүлэх явдал болно. Нөгөө талаар баруун бүсийн хөгжил, тогтвортой байдлыг ахиулж баруун бүсийн ард түмнийг хамтаар баяжуулах, Хятадын өөрчлөлт нээлттэй бодлого хил хязгаарын тогтвортой байдал, үндэстний нэгдэл нягтралд ашигтай орчин бий болгож өгөх явдал болно. Иймээс Хятадын баруун бүсийн хөгжил, тогтвортой байдал нь Монгол улсын цэцэглэл

хөгжилд таатай гадаад орчин бүрэлдүүлэн өгч, Монгол улсын эдийн засгийн хөгжилд ихээхэн түлхэц өгөх болно.

/Хоёр/ Хятадын өөрчлөлт нээлттэй бодлого эдийн засгийн хөгжлийн гол хандлага баруун бүс руу шилжихийг дагалдан, Хятадын баруун хойт бүсийн хөрш орнуудаас Хятадын өөрчлөлт, нээлттэй бодлого, эдийн засгийн хөгжлийн стратегид эзлэх байр суурь, үзүүлэх үүрэг улам дээшлэх болно. Ялангуяа Монгол улс нь БНХАУ-ын Умард, Баруун хойт, Зүүн хойт гурван том бүстэй уул усаар холбогдон хиллэдэг бөгөөд хоёр орны хилийн шугамын урт 4673 км юм. Энэхүү газар зүйн онцгой байршлын давуу тал нь хоёр орны харилцаа, эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаанд бусад зүйлээр орлуулж болшгүй ашигтай нөхцөл болж байна. Хоёр орны эдийн засаг нь нэлээд их харилцан нөхвөрлөх чанартай бөгөөд хоёр орны улс төрийн харилцаа ч маш сайн юм. Иймээс баруун бүсийг хөгжүүлэх стратегийн түлхэц доор, Хятад-Монгол хоёр орны эдийн засаг худалдааны хамтын ажиллагаа, улс хоорондын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа улам өргөжин гүнзгийрч, хоёр орон, хоёр орны ард түмэнд эдийн засгийн нэн их ашигтай байх болно.

/Гурав/ Хятадын баруун бүсийг хөгжүүлэх стратегийн холбогдох мэргэжилтэнүүд, шинжлэх ухааны нотолгоо гаргаж, баруун бүсийн хөгжлийг түргэтгэх хоёр замыг дурдаж, түүнээ “Алтан хонгил” хэмээн нэрлэсэн байна. Түүний нэг нь Хөх мөрний эдийн засгийн бүс, нөгөө нэг нь Лунланий эдийн засгийн бүс, тэр нь зүүнээс баруунш Хятадын дунд хэсгээр өнгөрдөг. ӨМӨЗО болон Зүүн хойт Хятадын мужууд энэхүү эдийн засгийн бүсийн хойт хэсэгт оршдог. Өвөр монголын умар зүгт нээлттэй болгохыг дагалдан Лунланий эдийн засгийн бүс нь олон улсын зах зээлд улам ойртож, Хятад-Монгол хоёр орон болон Хятадын ӨМӨЗО, Монгол улсын хоорондох эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа, олон улсын хоорондох хамтын ажиллагаанд асар том олон улсын зах зээл, орон зай бий болгох болно.

/Дөрөв/ Хятад улс, Дэлхийн Худалдааны Байгууллагад элссэн нь баруун бүсийн хөгжлийг түргэтгэх ажлыг улам ахиулж, Хятадын баруун бүс нь олон улсын асар том зах зээл болох нь дамжиггүй. Энэ нь Монгол улсын эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлж, Хятад-Монголын эдийн засгийн харилцан нөхвөрлөх шинжийг нь нэн ахиулж хоёр орны, хоёр талын болон олон улсын хамтын

ажиллагаанд илүү таатай боломж бий болгох болно. Хоёр орны эрчим хүч, зам харилцаа, холбоо, байгаль орчны хамгаалалт, худалдаа болон аялал жуулчлал зэрэг салбарын хамтын ажиллагаа тасралтгүй өргөжин эрчимжиж, хоёр орны XXI зуунд хандсан урт хугацааны, тогтвортой, сайн хөршийн найрамдалт харилцаанд маш чухал идэвхтэй нөлөө үзүүлэх болно.

**Хоёр. Хятад-Монгол хоёр орон боломжийг ашиглан
эдийн засаг худалдааны хамтын ажиллагаагаа
түргэтгэвэл зохино**

Эдүгээ Хятад-Монголын эдийн засгийн хамтын ажиллагаа нэлээд түргэн хөгжиж байгаа боловч хамтын ажиллагааны төслийн чанар, шат давхарга нь нэлээд доор, хоёр орны улс ардын аж ахуйн хөгжилд чухал байр эзэлдэг аж үйлдвэр хөдөө аж ахуйн талаар хамтран ажиллаж байгаа төсөл тун бага, хоол хүнс, үйлчилгээний салбарын хамтын ажиллагаа нэлээд их хувийн жин эзэлдэг. Иймэрхүү байдал нь өнөөгийн хоёр орны улс төрийн харилцааны хөгжлийн төвшин ба XXI зуунд хандсан урт хугацааны тогтвортой сайн хөршийн найрсаг харилцааны стратегийн шаардлагатай тун нийцэхгүй байна. Хоёр орон бодит байдалдаа тулгуурлан, алсыг харж, харилцан ашигтай хамтран ажиллах, хамтаар хөгжих зарчмын дагуу Хятадын баруун бүсийг хөгжүүлэх түүхэн завшааныг ашиглан, эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг түргэн хөгжүүлбэл зохино. Энэ бол хоёр орон, хоёр орны ард түмний бодит ашиг тус, хэтийн зорилгод нийцэх юм. Хоёр орны бодит байдалд тулгуурлан дараахь хэдэн талын хамтын ажиллагааг эрчимжүүлбэл зохино.

1. Хятад, Монгол хоёр орон худалдааны чөлөөт бүсийн бүтээн байгуулалтаа эрчимжүүлбэл зохино.

Хятад орон өөрчлөлт, нээлттэй бодлогыг хэрэгжүүлсэнээс хойш боомтын бүтээн байгуулалтыг түргэтгээд, Эрээн хотыг гадаадтай харилцах байгууллага ба хилийн хамтарсан шалган байцаах

байгууллага бүхий, төрөл бүрийн дэд бүтцийн тоног төхөөрөмж, чадал бүрэн гүйцэт төрийн нэгдүгээр зэрэглэлийн боомт болгосон байна. Монгол улсын Замын-Үүдийн боомт ч сүүлийн хэдэн жилд их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, дэд бүтцийн тоног төхөөрөмж, шалган нэвтрүүлэх чадал нь ихээхэн сайжирсан байна. Одоо Хятад-Монгол хоёр орон Эрээн хот, Замын-Үүдийн боомтыг түшиглэж хилийн ойролцоо худалдааны чөлөөт бүс байгуулах нөхцөл нэгэнт төлөвшсөн байна. Иймийн тулд хоёр талаар аль болох түргэн саналаа нэгтгэж, баруун бүсийн хөгжлийг түргэтгэж байгаа ашигтай тохиолыг ашиглаж хамтаар бүтээн байгуулах, хамтаар хөгжүүлэх хамтаар ашиг олох зарчмын дагуу идэвхтэйгээр бизнесийн хүрээнийхэнийг урьж хөрөнгө оруулж байгаал худалдааны чөлөөт бүсээ худалдаа, үйлчилгээг гол болгож, экспортын чиглэлтэй боловсруулах үйлдвэрийг чухалчилж, олон улсын худалдаа, аялал жуулчлал, үйлчилгээ, боловсруулах зэрэг олон талт, харилцан нөхвөрлөсөн, нээлттэй, үндсэн дамнасан, эд хөрөнгө, хүмүүс, хөрөнгө мөнгө, мэдээллийн урсгалын төв болговол зохино. Товчоор хэлбэл, худалдааны чөлөөт бүс байгуулах явдал бол хоёр орны эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны шат давхаргыг дээшлүүлэх чухал арга болно. Тэр нь хоёр орны эдийн засаг худалдааны хамтын ажиллагаа, олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа болон хоёр орны эдийн засгийг түргэн хөгжүүлэх, урагш ахиулахад чухал үүрэгтэй юм.

2. Хятад-Монгол хоёр орон дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээн дэх хамтын ажиллагаагаа эрчимжүүлбэл зохино.

Хятад-Монгол хоёр орны хооронд дэд бүтцийн бүтээн байгуулалтын талаар хамтран ажиллах өргөн хэтийн төлөвтэй юм. Монгол Улсын Их Хурлаас “Шинэ мянганы зам”-ын төслийг батлаад байна. “Мянганы зам” нь баруунаас Баян-Өлгий аймгаас эхэлж зүүнш Дорнод аймагт хүрч, хойт тал нь Алтанбулагаас эхэлж урагш Замын үүд хүрэх нийт 10 мянга гаруй километр урт, БНХАУ, ОХУ-д нэвтэрч, Европ, Азийн эх хуурай газрыг холбосон чухал засмал зам, Монгол улсын эдийн засгийн хөгжлийн том судас болно. Монгол орон баруун бүс нутагтаа авто замын сүлжээ байгуулж, Цагаан нуур-Ховд-Алтай боомтоор дамжин БНХАУ-

ын Шинжааны өндөр хурданы замтай холбохоор төлөвлөж байна. “Мянганы зам” төсөл дэх баруун бүсийн зам тавигдсан тохиолдолд Баян-Өлгий аймгийн төвөөс Улаанхус-Хөх-Элбэгийн мал аж ахуйн бааз, Таван Богд уулаар өнгөрч Төв Ази-Араб-Газрын дундад тэнгис болон Европ-Балтийн тэнгис хүрэх хоёр засмал замтай болно.

Зүүн хойт Ази, Төв Ази болон Европын хоорондох худалдаа тасралтгүй өргөжиж байгаа өнөө үед, цаг хугацаа, зардал гэсэн хоёр хүчин зүйлийг харгалзаж, холбогдох орнууд Монголын нутаг дэвсгэрээр дамжих хуурай замын тээвэрийг улам сонирхох болж байна. Зүүн хойт Азийн орнууд Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжиж Европод хүрдэг төмөр зам хоёр бий: Нэг нь Пусан-Сөүл-Синийжү-Даньдүн-Цагаан хот-Аршаан-Чойбалсан-Чита-Европын чиглэлийн зам. Нөгөө нь Солонгосын хойг-Түмэн гол /эсвэл Хүйчүнь буюу Даньдүн/ -Тунляо-Эрээн хот-Замын-Үүд-Улаанбаатар-Эрхүү-Европын чиглэлийн зам болно. Үүнээс Аршаанаас Чойбалсан хүрэх төмөр зам бол Зүүн хойт Азийн орнууд Европод нэвтэрэхэд заавал өнгөрөх зам бөгөөд энэ төмөр зам тавигдвал Монгол улс бас нэг далайн гарцтай болно. Иймээс, Монгол улсын Засгийн Газар Дорнод аймгийн Чойбалсан хотоос Аршаан хүрэх төмөр зам тавих ажлыг маш чухалчилж байна. Монгол улсын Засгийн Газар Азийн хөгжлийн банктай хамтран “Түмэн голын төсөлд” буцалтгүй тусламж үзүүлж, БНХАУ-ын Аршаанаас Монгол Улсын Дорнод аймгийн Чойбалсан хүртэлх төмөр замыг өргөтгөх техник, хөрөнгө мөнгөний баталгаа болгох асуудлаар Азийн Хөгжлийн Банктай зөвдөлцөж байна. Мянганы зам болон Аршаанаас Чойбалсан хот хүрэх төмөр зам тавигдсаны дараа Монгол Улс нь авто зам, төмөр замаар БНХАУ-тай холбогдож, хоёр орны хоорондох эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг ахиулахаар үл барам, Хятад-Монгол хоёр орон хийгээд Зүүн хойт Азийн орнууд, Төв Ази ба Европын орнуудын хоорондох харилцаа, хамтын ажиллагааг ахиулж, хоёр орны эдийн засгийн хөгжлийг түргэтгэх болно.

Эдүгээ Монголын эдийн засаг сэргэн хөгжиж байгаа энэ үед хөрөнгө мөнгө дутагдаж байгаа тул “Мянганы зам” ба Чойбалсангаас Аршаан хүрэх төмөр замыг засахад олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлж, олон улсын байгууллага болон бусад орны хөрөнгө оруулалт, тусламжийг түшиглэвэл сая цаг алдалгүй урагштай хийж дуусгаж чадна. Хятадын баруун бүс нутагт

барилгын төслийн зураг төлөвлөгөө хийх, бүтээн байгуулах удирдах талаар нэлээд хүчин чадалтай барилгын аж ахуйн нэгж төлөвшсөн, дунд баруун бүсэнд хөдөлмөр хүчний баялаг сайтай тул Хятад-Монгол хоёр орон ажиллах хүч, гадаадын барилгын тендер дааж авах зэрэг талаар хамтран ажиллах хэтийн төлөв сайтай юм. Хятадын баруун бүсийг хөгжүүлэх тохиолыг ашиглан хүчин чадал сайтай компани, аж ахуйн нэгжийн Монгол улсад очиж “Мянганы зам” ба Чойбалсангаас Аршаан хүрэх төмөр зам тавих ажилд олон хэлбэрээр идэвхтэй оролцохыг урамшуулбал зохино. Ингэх нь хоёр орны найрамдалт хөршийн харилцааг бэхжүүлж, эдийн засгийн хөгжил, нийгмийн дэвшилд идэвхтэй үүрэг гүйцэтгэх нь дамжиггүй.

3. Хятад-Монгол хоёр орон ашигт малтмалаа олборлох давуу талаа харилцан нөхвөрлөвөл зохино.

Хятад орны газар нутаг өргөн уудам, уурхайн баялаг маш элбэг, нөөц баялагыг нь тодорхойлсон 151 зүйлийн уурхай байгаагаас чанар сайтай нь 45, уурхайн нөөц өртөг нь ОХУ, АНУ-ын дараа дэлхийд гуравдугаар байранд ордог. Гэтэл Хятадын уурхайн баялгийн хүн бүрт ногдох дундаж хэмжээ нь дэлхийн дундаж хэмжээний 1/2-д ч хүрэхгүй. Ялангуяа улс ардын аж ахуйд чухал байр эзэлдэг алт, мөнгө, зэс, хар тугалга, төмөр, манган, уран, бор, алмаз, цагаан алт, калийн давс, газрын тос, байгалийн хужир зэрэг нь улс ардын аж ахуйн хөгжлийн шаардлагатай зохицохгүй байна. Монголын уурхайн баялаг харьцангуй элбэг, геологийн шинжилгээнээс үзвэл, Монголын газрын хэвлийд 80 гаруй төрлийн уурхайн хүдэртэй. Одоо илрүүлээд байгаа 500 гаруй уурхайн ордны дотор газрын тос, байгалийн хий, алт, уран, зэс зэрэг нь дэлхийн эхний арван байрыг эзэлдэг.

Одоо Монголд хөрөнгө мөнгө дутагдаж байгаа нь эдийн засгийн хөгжлийг хязгаарлах хүчин зүйл болж байгаа бөгөөд, гадаадын хөрөнгийг ашиглаж уурхайн баялгаа зүй зохистой нээж ашиглах нь Монголын эдийн засгийг хөгжүүлэх үр дүнтэй аргын нэг болно. Иймээс хоёр тал байх, байхгүйгээ харилцан солилцож, давуу талаа харилцан нөхвөрлөж, хамтаар хөгжих зарчмыг баримтлаж, Монгол улсын хүн ам цөөн хөдөлмөр хүч дутмаг, уурхайн баялаг элбэг, Хятадын хүн ам ихтэй, ажиллах хүчний баялаг сайтай, уурхайн баялаг дутагдаж байгаа энэхүү харилцан нөхвөрлөх чанар онцлогт тулгуурлан Монголын ашигт малтмалын зах зээлд Хятадаас хөрөнгө оруулж, олборлох боловсруулах ажил

хийж, Монголын уурхайн баялгийг хамтаар нээх нь хоёр орны XXI зуунд хандсан харилцан ашигтай хамтын ажиллагааны хэтийн төлөвт нийцэх юм.

4. Хятад-Монгол хоёр орон худалдааны хамтын ажиллагаагаа бүх талаар эрчимжүүлбэл зохино

Хятад-Монголын худалдааны хамтын ажиллагаанд хил худалдаа оншгой байр суурь эзэлдэг. Одоо Хятад ӨМӨЗО болон Монгол улсын хооронд хилийн 18 боомт байдаг нь Хятад, Монголын хил худалдааг хөгжүүлэх, хил орчмын орон нутгийн засгийн газрын хоорондын хамтын ажиллагаанд таатай нөхцөл бий болгож байна. Хоёр орон хил худалдаагаар дамжиж хилийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх, хоёр орны сайн хөршийн найрамдалт харилцааг ахиулах бүрэн боломжтой юм.

Хятад, Монгол хоёр орны хил худалдааны нөөц боломж их байна. Хоёр орон, БНХАУ-ыг Дэлхийн худалдааны байгууллагад элссэн, баруун бүсийн хөгжлийг түргэтгэж байгаа ашигтай тохиолыг болон газар зүй, боомтын давуу талаа ашиглаж, юуны түрүүнд хил худалдаа, орон нутгийн засгийн газар хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлбэл зохино. Өөрөөр хэлбэл, хоёр орон хилийн худалдааг гол болгож, хамтран ажиллах хүрээгээ аажмаар өргөтгөж олон улсын зах зээлийг нээж, ганц хил худалдаанаас өөр олон төрлийн худалдааны арга замыг эрэлхийлбэл зохино. Цулгүй зах зээлээс олон талт зах зээлд шилжих хэрэгтэй. Худалдааг гол болгож байснаасаа эдийн засаг техникийн хамтын ажиллагаа руу өргөжин тэлэх хэрэгтэй. Тэгэхдээ гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг тэргүүнд тавьж, худалдаа, санхүү, экспортийг голлосон боловсруулах үйлдвэр, хүнсний үйлчилгээ, аялал жуулчлал, тээвэр зэрэг олон арга зам, олон давхарга, олон талт хамтын ажиллагааг идэвхижүүлж, Хятад Монголын хоорондох эдийн засаг худалдааны хамтын ажиллагааг шинэ дээд түвшинд гаргах хэрэгтэй байна.

5. Хятад-Монголын аялал жуулчлалын хамтын ажиллагааны хэтийн төлөв

Дэлхийн эдийн засгийн тасралтгүй хөгжихийн хэрээр “Далд

худалдаа” хэмээгдсэн аялал жуулчлалыг улс орнуудын засгийн газрууд ихээхэн анхаарч байна. Аялал жуулчлалыг XXI зууны ихээхэн ирээдүйтэй салбар гэж холбогдох мэргэжилтэнүүд үзэж байна. Хятад-Монгол хоёр орны аялал жуулчлалын салбарт, хамтран ажиллах хэтийн төлөв ихтэй юм. Хятад Монголын хоорондох эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа тасралтгүй өсөн нэмэгдэхийн хэрээр хоёр орны аялал жуулчлалын хамтын ажиллагаа хөгжих нь дамжиггүй. Хятад бол 1,3 тэрбум хүн ам бүхий том орон, дэлхийн хамгийн том аялал жуулчлалын зах зээл болно. Хятад орон өөрчлөлт нээлттэй бодлого хэрэгжүүлсэнээс хойш аялал жуулчлал эрчимтэй хөгжив. Иймээс Хятад, Монголын аялал жуулчлалын хамтын ажиллагаа нь Монголын аялал жуулчлалын ажилд асар их түлхэц үзүүлэх болно. Ялангуяа, Хятад-Монгол хоёр орон олон улсын чанартай аялал жуулчлалын хамтын ажиллагаа хийж, аялал жуулчлалын төслийг хамтаар нээн хөгжүүлж, хоёр оронд байгаа Европ Азийнхан заавал өнгөрдөг эх хуурайн гүүр хэмээх энэхүү газар зүй, боомтын давуу талаа гүйцэд ашиглаж, Хятадын аялал жуулчлалын асар том захаар түшиг болгож, Зүүн хойт Ази, Зүүн өмнөд Ази, цаашилбал Европын орнууд, Төв Азийн орнуудын аялал жуулчлалын үйлсийг хөгжүүлэх нь жуулчлалыг өргөтгөх таатай нөхцөл болно. Иймээс хоёр орны аялал жуулчлалын хамтын ажиллагаа нэн өргөн хэтийн төлөвтэй хөгжлийн асар их нөөцтэй юм.

Хятад хэлнээс орчуулсан Л.Бэгзжав